

МОНГОЛЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС-ийн Сургалтын албаны дарга, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: төрийн мэдээлэл харилцаа, сайн засаглал, хямралын үеийн ПР, төрийн бодлого, мэдээлэл харилцааны агуулга, билэгдэл

Төрийн мэдээлэл харилцааны хөгжил төлөвшил, нөлөөллийн тухай онцлон үзэх болсон нь бодит шалтгаан, хүчин зүйлээс улбаатай юм. Хэдийгээр төрийн мэдээлэл нь сэтгүүл зүй хэмээх хүний үзэл бодолтой байх, илэрхийлэх, цаг үе, нийгмийнхээ бүхий л үйл явдал, баримт үзэгдлийг мэдэх эрэлт хэрэгцээ, төрөлх эрхээс хол ангид, бүр "эсрэг" утга тэмдэгтийн ертөнц мөн боловч ардчилал, сайн засаглал, нээлттэй байдал, зөвшилцөл зэрэг орчин үеийн улс төрийн амьдралын эрүүл саруул, зүй зохист орчин хэм хэмжээ, дэг журмын салшгүй нэгэн хүчин зүйл болоод байгаа билээ. Түүнчлэн Монголын өнөөгийн ОНМХ-ийн нийтлэл нэвтрүүлгийн агуулгын томоохон орон зайг төрийн мэдээлэл эзэлж, нөлөө байр суурийнхаа хувьд тэргүүлэгч, олон нийтийн санаа бодлын гол үндсэн сэдэв, асуудлыг тодорхойлогч харилцааны төвшинд хүрээд байна. Монголын төрийн бодлого, үйл хэрэг хэвлэл мэдээллээс шууд шалтгаалдаг, зүг чигээ олдог жишиг тогтоод багагүй хугацаа өнгөрлөө. Мөн төр засаг улс төрийн хүчнүүдийн анхаарал сонирхол тэр бүү хэл хөрөнгө мөнгө мэдээллийн

хэрэгслүүдийг хянах, эрх ашиг нэр нөлөөгөө хамгаалуулах зорилгод чиглэх болсон. Телевизийн оргил цагийн (19-22 цаг) 59-80 болон өдөр тутмын сонины эхний нүүрүүдийн 72-93 хувь¹ нь тус тус төр засаг, улс төрийн бодлого, үйл амьдрал тойрсон зөрчил үгүйсгэл ухуулга тайлбар бүхий мэдээ, ярилцлага, өгүүлэл, сурвалжлага эзэлж, хамгийн их үзэгчтэй нэвтрүүлгийг тэргүүлж байгаа нь дээрх дүгнэлтийг тодотгож буй хэрэг. Гэхдээ төрийн мэдээлэл харилцааг улс төрийн сэтгүүл зүйтэй адилтгаж болохгүй ба хир хэмжээ, хүрээ нь хэтийдвэл үзэл бодол, мэдээллийн дарангуйлал, бие хүний эрх чөлөө, бие даасан байдлыг хязгаарласан хэрэг болно. Тиймээс төрийн мэдээлэл харилцааг олон нийтэд мэдээлэл хүргэх, улс орон, нийгмийн чухал, онцгой тулгарч буй бэрхшээл саадыг шийдвэрлэх засаг, эрх мэдэлтнүүдийн бодлого байр суурь ямар байгааг тодотгох, эцсийн дүндээ төр ба нийгэм хоорондын зөвшилцлийг хангахад үйлчилдэг тогтолцоо хэмээн үзэх хэрэгтэй.

Гэвч энэхүү үзэл хандлагаар Монголын өнөөгийн төрийн мэдээллийн орон зайг үнэлж дүгнэхэд нилээд сөрөг дүр зураг гарна. Нэг талаас хүчтэй, бүхнийг ивээгч халамжийн төрийг хүссэн олон нийтийн шахалт тулгалт эрхшээгч байгаагаас нийгмийн өөрийн хөгжил, эрх ашгаас ангид өөр, амлалт,

бэлэнчлэх сэтгэлгээг хөхүүлэн дэмжсэн мэдээллийн эрэлт, нөгөө талаас эрс туйлшрал, зөрчил үгүйсгэлээр эрх мэдэл нөлөөгөө тогтоох зорилгот улс төрийн нам эвсэл, хүчнүүдийн ухуулга сурталчилгааны тулгалтын орчинд бодит үнэн мэдээллийн үнэ цэнэ, нөлөө хүчгүйдэж байгаа юм. 2011 оны төрийн мэдээллийн дийлэнх хувь хэмжээг “Эх орны хишиг”, Оюу толгой, Таван толгой зэрэг уул уурхайн томоохон төсөл, УИХ-ын сонгуулийн хуулийн шинэчлэлт, банк санхүүгийн хямралыг зохицуулах төрийн оролцоо, шинэ намуудын бүртгэл тойрсон маргаан гэсэн нийгэм эдийн засгийн бодит хөгжил, эрх ашгаас өөр асуудал, сэдэв эзэлж байлаа.

Харин Өрнийн ардчилал, зах зээл өндөр хөгжсөн улс орны төрийн мэдээлэл харилцаа нь татвар төлөгчдийн өмнө хүлээх хатуу чанд үүрэг хариуцлага, хууль дээдлэх ёс, хүний эрхийг дээдлэх нийгмийн гэрээ гэсэн гурван тулгуур хүчин зүйлийн хүрээнд томьёологддог. Энэхүү нөхцөл дэг журмыг ч хүчтэй нөлөө бүхий сөрөг хүчин, нэр хүндтэй хариуцлагатай хэвлэл мэдээлэл, мэдээлэл бүхий иргэдийн идэвх байр сууриар тогтоодог учиртай. Тэгээд ч төрийн мэдээлэл харилцааг ихэнх тохиолдолд “хямралын үеийн PR эсвэл спиндоктор (spin - эргүүлэх)”² гэсэн утгаар тайлбарладаг. Өөрөөр хэлбэл хүчтэй сөрөг хүчний хяналт, бодит эрх мэдэл болоод тэнцвэртэй нэр хүндтэй мэдээллийн байгууллагын нөлөө нь татвар төлөгчид, олон нийтийн санаа бодлын хүч дэмжлэгээр тэтгэгдэн төрийн мэдээлэл харилцааны орчныг үнэн бодитой, хариуцлагатай, нийгмийн эрх ашгийг дээдлэгч агуулга үзэл баримтлалынх болгон төлөвшүүлдэг байна.

Америкийн “Hill&Knowlton” компанийн ерөнхийлөгч Роберт Диленшнейдер “Төр засаг нь иргэдийн байнгын хяналт, сэрэмж болон хэвлэл мэдээллийнхэний анхаарал сонирхлын төвд байдаг америкийн амьдралын салшгүй

нэгэн хэсэг юм. Тиймээс ч түүний буруу алдаатай үйл бодлогыг бүх нийтээр хэлэлцэж, дүгнэж байдаг”³ гэсэн нь санаандгүй зүйл биш ээ. Тэр засгийн мэдээллийн байгууллага нь нэг талаас өдөр тутмын цаг үеийн асуудал үйл явдлыг (ЕТГ-аас бэлтгэдэг “Сүлд”, засгийн газрын “Нээлттэй засаг” зэрэг) нөгөө талаас урт бүрэн эрхийн хугацааны бодлого, үзэл баримтлалыг (олон нийт, мэдээллийн албадын үндсэн үүрэг зорилго) хүргэх үндсэн хоёр чиглэлд ажил хэргээ зохион байгуулдаг нийтлэг жишээтэй. Үүнийг өөрөөр мэдээлэл харилцааны тактик (цаг үеийн) болон стратеги (урт, бүрэн эрхийн хугацааны) хэсэг, үйл явцын хүрээ ч хэмээн ангилж болно. Тэгээд ч АНУ-ын Ерөнхийлөгчийн мэдээлэл харилцаа нь ерөнхийдөө юуны тухай хэрхэн болон хаана хэзээ гэсэн бодлого чиглэлээр тодорхойлогддог гэж байгаа.

Ийм үйл ажлын анги хуваарь нь төрийн өндөр албан тушаалтны мэдээлэл харилцааны зөв, таатай орчныг бүрдүүлж өгдөг ба үр дүн ч бодитой байдаг. Ер нь өрнийн нийгэм, улс төрийн соёл, ухамсрын орчин ахуйд төр засгийн PR гэж үгүй бөгөөд ийнхүү үзэх нь татвар төлөгч олон нийтийн дунд зүй бус, ухуулга сурталчилгааны “машин” мэтээр төсөөлөгдөх аж. Паблик рилейшнз нь илүү бизнес, санхүү, арилжааны ертөнцийн ойлголт төдийгүй “брэнд”, хариуцлагатай эдийн засаг, эрсдлийн үеийн гэсэн тодорхой мэдээлэл харилцааны зорилгод нийцдэг үйл хэрэг юм. Харин төрийн байгууллагын хувьд мэдээллийн нээлттэй байдал, иргэдийн санал хүсэлтийн идэвх, нийгэм олон нийтийн хэлэлцүүлэг зэрэг үнэлэлт хандлага нь зохимжтой.

Тиймээс ч Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилж, ажил хэрэг болгож буй “Иргэний танхим”, “Боловсрол” телевизээр цацдаг “Би иргэн” хэлэлцүүлэг нэвтрүүлэг нь үр нөлөөгөө үзүүлж байгаад эргэлзэх

зүйлгүй. Гэхдээ дээр өгүүлсэнчлэн иргэдийн идэвхтэй бие даасан оролцоо, нийгмийн өмнө хүлээсэн төрийн мэдээллийн нээлттэй байдлын жишээ бодит үр дүн болсон гэвэл үнэнээс холдоно. Энэхүү танхим, нэвтрүүлэг нь төрийг дээдлэх, төрд бүхнээ даатгах олон нийтийн санаа бодол, хандлагын нэг хэлбэр, түүнийг хөхүүлэн дэмжсэн улс төрчийн пиарийн оролдлого төдий төвшинд байгаа нь харамсалтай. Ер нь манай улс төрчид Өрнийн мэдээлэл харилцааны жишээ жишгийг өнгөц хэлбэр төдий дууриах, нийгэм хүний хөгжлийн мөн чанар зайлшгүй хүчин зүйлийн төвшинд үнэлэхгүй байгаа нь олон зүйл, асуудлаар нотлогддог. Өөрөөр хэлбэл сэтгүүлчидтэй хийх уулзалт, ярилцлага болон үг хэлэх, мэдэгдэл хийснээр өөрсдийн зорилго үүргийг хязгаарладаг. Гэтэл мэдээлэл хийх хэлбэр, давталт, тасралтгүй байдал бус харин нийгэм, олон нийтэд ямар үзэл санаа, агуулгыг хүргэх вэ гэдэг нь бүхнээс чухал байдаг. Төр засаг нь нийгмийн дэг журам, хэм хэмжээг хамгаалах, хөгжил өөрчлөлтийн таатай нөхцөл орчныг бүрдүүлэгч үүрэг бүхий тогтолцооны хувьд мэдээллийн орон зай, олон нийтийн санаа бодлын хүрээнд шинэ, тулгамдсан, зайлшгүй асуудлыг нээн тодорхойлогч бүхий л хүч боломжийг тодруулагч, нэгтгэгч байх ёстой.

Харин манай төрийн мэдээлэл нь хэвлэл мэдээллийнхэнд тал зассан, нийгэм, олон нийтийн шүүмжлэлийн "гал унтраах" дадал хэвшилд автсан, асуудлын мөн чанарыг бус цаг үеийн шалтагийг зөөлрүүлэх хандлагад чиглэсэн байгаа нь үр нөлөөгүй, байр суурьгүй урсгал шинжтэй байгаагийн гол шалтгаан болоод байна. Тэгээд ч "төр хэзээ ч асуудлыг шийдэж чаддаггүй учир нь өөрөө асуудлын гол шалтгаан, "эзэн" нь байдаг" гэсэн үгийн утга үнэн манай мэдээллийн орон зайд илт тодорхой нотлогдож байна.

Төрийн бодлого, үйл хэрэг нэгдмэл, тууштай, баттай гуйвашгүй байх ёстойн

адил мэдээлэл, харилцааны агуулга, билэгдэл, үзэл баримтлал хатуу голч байх нь чухал. Энэ тухай ч Ж.Бушийн засгийн газрын батлан хамгаалахын сайд Дик Чейни "...Хэвлэлийнхэнд сайд Дик Чейни өгч болохгүй. Мэдээж давуу байдал өгч болохгүй. Мэдээж үүнийг тэд эсэргүүцэх болно. Сэтгүүлчид юу чухал, юу чухал бусыг тодорхойлохыг эрмэлздэг. Хэрвээ бид үүнийг нь хүлээн зөвшөөрвөл тэд манай засгийн газар, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дэвсэх болно"⁴ хэмээн тэмдэглэсэн нь бий. Үнэхээр ч төрийн мэдээлэл нь нийгмийн зүй ёсны, зохист хөгжил, орчинд нийцсэн шийдвэр, хууль эрх зүйн бодлого, итгэл үнэмшил бүхий мөрийн хөтөлбөр үйл хэрэг хийгээд тууштай, нэгдмэл, нарийн зохион байгууллалттай үзэл санаа тайлбар, агуулгын харилцаагаар дэмжигдэн сая үр дүнд хүрэх нь ойлгомжтой.

Гэтэл манайд ийм төрийн мэдээллийн чанар үгүйлэгдсээр байна. Шинээр томилогдсон Ерөнхий сайд бүр боловсролын шинэчлэлтэд уриалж, эцэстээ намынхаа дотоод зөрчилд "унадаг" нийтлэг дүр зураг мэдээллийн орон зайд хэвшил болсоор удлаа. Энэ нь нөгөө л эрс үгүйсгэлийн, шүүмжлэлт, бүхнийг бэлэнчлэгч, олон нийтийн санаа бодол, түүнийг хөхүүлэн дэмжигч хэвлэл мэдээллийнхэний довтолгоонд хүчин мөхөсдөж буйн үр дагавар билээ. Түүнчлэн улс төр-эдийн засгийн бүлэглэл, томоохон төлөөлөл бүр өөрийн эзэмшил, хараат телевиз, сонин, вэб сайт зэрэг мэдээллийн хэрэгсэлтэй болж, бүр өөр хооронд нь нэгтгэж байгаа нь төрийн өөрийн гэсэн үзэл баримтлал, чиг хандлагыг бүрхэгдүүлэх боллоо. Өөрөөр хэлбэл олон нийтийн санаа бодлын хэт ноёрхол, тулгалтад "боорлуулсан", улс төр эдийн засгийн бүлэглэлийн явцуу эрх ашигт хөтлөгдсөн өнөөгийн мэдээллийн их түрэлтэд төрийн эрүүл оюун ухааны "хана" нуран унаж байна гэсэн үг. Ийм хамгийн бодитой жишээ нь

2011 оны 1-р сарын 1-нээс УИХ-ын байнгын хорооны хуралдаанд сэтгүүлчдийг оролцуулахгүй байх шинэ журам, дэг батлагдаад сар хүрэхгүй хугацаанд цуцлагдсан дуулиан юм. Төр өөрийн мэдээллийн давуу байдлаа хадгалах, хэвлэлийнхэний хэт нөлөө дарамтаас ангид байх, эрүүл саруул шийдвэр гаргах гээд олон зүйл асуудалд шинэ дэг нь эерэг нөлөө үзүүлэх байсан ч нэгэнт төлөвшин тогтсон олон нийтийн санаа бодлын хүчирхийллийн өмнө тэссэнгүй.

Мэдээж би энд олон нийт нийгмийн мэдэх эрхийг үгүйсгээгүй бөгөөд хэргийн учир нь хүчтэй бүхнээ даатгагч ивээлт том төрийг хүсэгч олон нийтийн тулгалт, дуулиан шуугиан, захиалгад ноёлуулсан телевизүүдийн бэлэнчлэх хандлага бүхнийг шийдсэнд оршино. Учир нь дээрх УИХ-ын хуралдааны дэгийн шинэ заалт нь нийгэм олон нийтэд мэдээллийг хаалттай болгох шалтгаан дагавар үгүй иргэншсэн, нээлттэй ардчилсан улс орны жишигт байдаг энгийн томьёолол байсан хийгээд сэтгүүлчид баримт, эх сурвалжийг өөрсдөө ашиглах боловсруулах үүрэг, мэргэжлийн ур чадварт нь нийцсэн алхам байсан юм. Тэгээд ч саяхны Ерөнхий сайдыг огцруулах тухай УИХ-ын 9 гишүүний гарын үсэг бүхий бичгийн мэдээллийг сонссон Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар, Эрдэнэ нарын хооронд болсон хэрүүл, зүй бус байдал нь олон нийтийн өнөөгийн төрийг үгүйсгэгч, доромж үзлийг хөөрөгдсөн хэрэг болоод өнгөрч байх жишээтэй.

Үнэхээр ч нийгэм нь нийгэм шиг, төр нь төр шиг байж сая мэдээлэл үр нөлөө, эрх мэдэлтэй байдаг нь бодит үнэн ажээ.

Өрнөд дахины улс төрийн тогтолцоо, соёлын хүрээнд төрийн байгууллагын мэдээллийн үүрэг зорилго нь дараах хүрээ хэсэгт тодорхойлогддог байна. Үүнд:

а) Мэдээлэл харилцааны бодлогыг урт хугацаагаар төлөвлөх;

б) “цаг үеийн (өдрийн) үзэл санаа буюу засаг захиргааны нэгж бүрдэл бүр өөр хоорондоо ямар нэг үгүйсгэл, зөрчил үгүйгээр нэгэн байр суурь үзэл тайлбарыг баримтлах;

в) улс төр-эдийн засгийн бүлэглээс ангид, чөлөөт мэдээллийн хэрэгсэлтэй нээлттэй шууд харилцах;

г) орон нутгийн хэвлэл мэдээллийнхэнд нээлттэй байх;

д) ОНМХ-үүдэд мэдээ, баримт, мэдэгдлийг бэлтгэх;

е) хүн амын бүхий л давхаргад уулзалт, яриа, үг мэдэгдэл хийх замаар харилцаа мэдээллийн олон аргыг ашиглах эдгээр болно.

Энэхүү үүрэг зорилгыг судлаач Жон Мальтиз “боломжит төвшин хүртэл нөлөөлөх тэр дундаа төрийн бодлого, байгууллагын талаар ямар мэдээлэл хэвлэлээр гарах хүртэл бүхий л эрх нөлөөг олох”⁵ хэмээн тоймлон дүгнэсэн нь учиртай хэрэг. Өөрөөр хэлбэл төрийн бодлого, үйл амьдралын талаар нийгэм олон нийтэд эерэг таатай ойлголт үнэлэлт бий болгох нь төрийн өөрийнх нь үүрэг хариуцлага болохоос хэвлэл мэдээллийн ажил зорилго биш гэсэн үг юм. Харин манай өнөөгийн бодит байдалд төр, түүний эрх мэдэлтнүүд сэтгүүлч, мэдээллийн хэрэгслийг худалдан авах, өөртөө татах, шагнал урамшуулал өгөх тэр бүү хэл өөрсдөө “сэтгүүлч, нийтлэлчид”-ийн ажлыг булаах үзэгдэл хавтайгарлаа. Тодруулбал, 25-р сувгийн “Дуусдаггүй яриа”, “ТМ” телевизийн “Монголоо шинэчилье”, “Боловсрол” телевизийн “Би иргэн” зэрэг нэвтрүүлэг нь төрийн албан хаагч, улс төрчдийн хөтөлбөр болтлоо өргөжиж, ТВ-5-ын “Монгол Улсаа хөгжүүлье” телевизийн “Зочны цаг”, UBS-ын “En Face” зэрэг оргил цагийн ярилцлагад төрийн ухуулга, сурталчилгаа зонхилж байгаа нь сайн зүйл биш ээ. Үнэхээр улс төр, сэтгүүл зүй хоёр “нэг уушигтай” болж, төр засаг бодлого, үйл ажлаа хэвлэл мэдээллээр

шууд сурталчлах нь хүний үзэл бодолтой байх төрөлх эрх, нийгмийн үнэнийг мэдэх зайлшгүй мөн чанартай харшилдаж буй хэрэг юм.

Тиймээс сэтгүүл зүй нь хүн хоорондын харилцааны үргэлжлэл, салшгүй хэсэг, нийгмийн оршихуйн зайлшгүй чанар гэдгийг бид улам бүр мартаж, мэдэх ёстойгоо мэдэж, ярих хэрэгтэйгээ умартаж, хоёр улс төрчийн хэрүүл, намуудын нэрийн бүртгэл, ямаа, ноолуур, үр тариа, сүүний нөхөн төлбөр, утаагүй зуух, Таван толгойн хувьцаа гээд төрийн оролцоо, халамж тойрсон асуудлаар мэтгэлцэх боллоо. Энэ ч учир төрийн мэдээлэл хэмээх ойлголт нийгэм, олон нийтийн харилцаатай нэгдэн уусч, яг юуг хэлээд байгааг тайлбарлахад төвөгтэй нөхцөл байдалд нэгэнт хүргэжээ. Тэгэх-

лээр энгийн ухамсрын төвшинд байтугай мэргэжлийн хүрээнд ч Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан зөвлөх, албаны дарга гэсэн гурван хүн ямар үүрэг, хариуцлагатайг тодорхойлоход төвөгтэй болжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч нараас хамгийн анх Р.Никсон "Олон нийттэй харилцах алба" болон хэвлэлийн төлөөлөгч гэсэн байгууллага, албыг бий болгосон нь учир шалтгаантай. Энэ нь юуны өмнө түүний хэвлэл мэдээллийнхэнтэй сөрөг зөрчилтэй ханддаг, нэн ялангуяа телевизийн дэлгэц сэтгүүлчдээс зугтдаг зан сэтгэхүйтэй холбоотой байж. Тэгээд ч телевизийн дүр төрх үгүй, өөртөө итгэлгүй, хүйтэн харагддаг нь Ж.Кеннедид ялагдсан гол шалтгаан нь байсан гэдэг.

Тэр үед Р.Никсон өөрийн амлалт, мөрийн хөтөлбөрөө сурталчилахаар АНУ-ын 50 мужаар тойрч байхад Ж.Кеннеди хамгийн олон хүн амтай, мэдээллийн томоохон хэрэгсэл төвлөрсөн хотуудад хүрч ажиллажээ. Энэхүү мэдээллийн хэрэгслийн хүч нөлөөг тооцоогүй сургамжаасаа санаа аван тэрээр өөрийн шинэ албаа олон нийтийн санаа бодлыг эерэгээр барих үйл зорилгод чиглүүлсэн хэрэг. Түүнчлэн Никсон өөрийн засаг захир-

гааныханд итгэл муутай, сөрөг мэдээлэл, тайлбар өгч магадгүй гэсэн эргэлзээтэй байснаас өөрийн анд Т.Клейнийг хэвлэл мэдээлэлтэй харилцах төлөөний хүнээ болгожээ. Ийнхүү Никсон нэг талаас хэвлэлийнхэнтэй шууд харилцах нөхцлөөс зугатан, бичиг, бэлтгэгдсэн асуултын хү-

«

Манай төрийн мэдээлэл нь хэвлэл мэдээллийнхэнд тал зассан, нийгэм, олон нийтийн шүүмжлэлийн "гал унтраах" дадал хэвшилд автсан, асуудлын мөн чанарыг бус цаг үеийн шалтагийг зовлруулэх хандлагад чиглэсэн байгаа нь үр нөлөөгүй, байр суурьгүй урсгал шинжтэй байгаагийн гол шалтгаан болоод байна.

»

рээнд мэдээллийн үүргээ гүйцэтгэхээр олон нийттэй харилцах албыг байгуулсан хэрэг. Гэтэл Г.Клейн сэтгүүлчидтэй эерэг сайн холбоотойн дээр бие даан бодлогоо тодорхойлох болсон нь Р.Никсоныг Хэвлэл мэдээллийн алба гэсэн огт өөр зорилго үүрэгтэй байгууллагыг санаачлахад хүргэжээ. Ийнхүү өдөр тутмын мэдээлэл харилцааны асуудал эрхэлсэн хэвлэлийн төлөөлөгч гэсэн албан тушаалтан "төрсөн" гэдэг. Сүүлд Г.Клейн "хэвлэлийн төлөөлөгч нь Ерөнхийлөгчийн дуу хоолой" байсан бол хэвлэл мэдээллийн алба нь байгууллагынх болон төлөвшсөн" хэмээн дурсан өгүүлжээ. Тэгээд ч мэдээллийн алба нь илүү сэтгүүлчид, мэдээллийн хэрэгслийнхэнтэй харилцах байгууллага болон төлөвшиж харин "хэвлэлийн төлөөлөгч" нь үе үе харагддаг

“даргын хүүхэлдэй”-д хувирсан түүх эхэлжээ.

Олон нийттэй харилцах алба нь дарга болон хэвлэл, телевиз радио, үг мэдэгдэл бэлтгэх, ерөнхий зохион байгуулалт гэсэн дөрвөн асуудал эрхэлсэн орлогчтойгоор байгуулагджээ. Мөн дөрвөн хэлтэс нь тус бүрдээ засгийн газрын тодорхой асуудлыг хариуцан долоо хоногт хоёр удаа тайлан гаргах үүрэг хүлээсэн нь Ерөнхийлөгчийн мэдээлэл тайлбарын уялдаа холбоонд эерэг нөлөө үзүүлэв. Тэдний тайлан ч мэдээлэл түгээх үйл ажиллагааг зөв ончтой болгох үндэс, нийгмийн илүү ойлголцол, таатай үнэлэлтийг бүрдүүлэв. Үүний дараа нийгмийн бүлэг, давхаргад чиглэсэн харилцааны алба байгуулагдаж, тухайн зорилгот хүрээний санаа бодлыг тандан, тэдний эрх ашиг сонирхлыг төрийн бодлогод хүргэснээр дэмжлэг, эерэг нэр хүнд олох зорилгод үйлчилж эхэлжээ. Гэвч дээрх хоёр нийгэм олон нийттэй харилцан албан үүрэг чиглэлийн хувьд давхцах зөрчилдөх явдал гарч Конгресстой ажиллах албыг бий болгосон гэдэг.

Олон нийттэй харилцах алба нь Ерөнхийлөгч болон бусад албаны хүмүүсийн мэдэгдэл тайлбарыг орон даяар нэвтрүүлэх, олон нийтэд хүргэх зарим үед сэтгүүлч бус нийтлэлч, эх сурвалжийн мэдээллийн ажлыг зохион байгуулах үүрэг хүлээнэ. Мөн гадаад бодлогын асуудлаар улс төрийн профессор, судлаач нарт мэдээлэл хүргэх мэтийн зорилгот хэрэглэгчдийн хүрээнд ажиллана. Ийнхүү 10 сарын хугацаанд 226 нийтлэл, мэдээллийг 308 900 мэргэжилтэн, нөлөө бүхий хүмүүст хүргэсэн тоон үзүүлэлтэд хүрчээ.

Сэтгүүлчид болон нийгмийн бүлгүүдийн харилцаа нь албан болоод албан бус байдлаар томъёологдож байв. Г.Клейн сэтгүүлчидтэй уулзахад нилээн цаг зарцуулж, нийгэм судлаачидтай олон нийтийн санаа бодлын талаар хэлэлцэн нийгэмд хүргэх

мэдээлэл асуудлаа тодорхойлж Цагаан ордонд танилцуулдаг жишиг тогтов.

Харин телевиз радио, сонины хэлтсийнхэн редактор, нийтлэлч, тоймчидтой холбоотой байж, Ерөнхийлөгчийн үг, үзэл тайлбарыг нийтлэл нэвтрүүлэгт олонтаа иш татагдах, холбогдох чиглэлд анхаарна. Үүнийг ч Ерөнхийлөгч Р.Никсон онцгой ач холбогдолтойд тооцож ихээхэн хүчин чармайлт тавьж байсан нь үр дүнгээ өгч сөрөг тал нь тасралтгүй, томоохон хүчээр дайрсан ч тэсч үлдсэн гэдэг. Тийнхүү Р.Никсон нь Л.Жонсоныг бодоход хэвлэлийнхэнтэй тэрсэлдэх, тэднийг шахахад бус харин дэмжлэг авах, зөвшилцөл ойлголцолд хүрэх бодлого явуулснаараа илүү оносон юм. Өөр нэгэн хэвлэл мэдээллийнхэнтэй үр ашигтай харьцаа, хатуу зарчимч бодлого явуулсан улс төрч нь Британийн Ерөнхий сайд “төмөр хатагтай” М.Тэтчер байсан юм. Түүний мэдээллийн мэргэжилтнүүд Ерөнхий сайдынхаа нэр төр байр суурийг олон нийтэд таалагдахад бус харин түүний зан чанар, зарчимч, тууштай дүр төрхөд чиглүүлж байсан нь учиртай. Мөн олон нийттэй харилцах шууд нээлттэй илэн далангүй арга хэлбэрийг илүүтэйд үзэж, үзэл баримтлал, тайлбараа жирийн хүн, цугласан олны өмнө хамгаалж, тодотгож байсан нь Тэтчерийн нэг давуу талыг бий болгов. Тэгээд ч төрийн бодлого нь ард иргэдийн үзэл, эрх ашиг сонирхлоор зүг чигээ тодорхойлж, шалгаж хянаж байхын үлгэр жишээг үзүүлж байсан гэдэг.

Ийнхүү нэгтгэн томъёолбол төрийн мэдээлэл харилцааны үндсэн таван зарчим байдгийг судлаач мэргэжилтнүүд тодорхойлжээ. Үүнд:

- **Цогц тогтолцоот байх** (төрийн байгууллагуудын бодлого, ажлын үр дүнг бодитой үнэлж дүгнэх зорилгот олон нийтийн санаа бодлын судалгаа дүгнэлтэд тулгуурлан хөтөлбөр, харилцааны хэлбэрээ тодорхойлох)

- **Зохион байгуулалт бүхий байх** (мэдээлэл харилцааны бүхий л үйл ажил

нь тодорхой дэг, хэмжээ төвшин, үечлэлээр зохион байгуулагдаж байх. Ийм жишээнд ОХУ-ын Ерөнхийлөгчийн жил бүр хийдэг 1000 сэтгүүлчийн уулзалт, манай АН-ын сар тутмын 4-11 уулзалт, Ерөнхий сайдын орон нутагт хийдэг арга хэмжээ зэргийг нэрлэж болно.)

- **Нээлттэй, ил тод байх** (төр засаг нь нийгэм олон нийтэд бодлого, үйл зорилго ил тод нээлттэй мэдээллэж, иргэдийн хяналт, оролцоо бодит хэрэг болгох үүрэгтэй)

- **Бүрэн дүүрэн байх** (ямар нэгэн шүүмжлэл, хяналтаас ангид хаалттай байхын тулд мэдээллийн урсгалыг хязгаарлаж болохгүй. Сүүлийн үед манай төр засгийн мэдээлэлд бүрэн дүүрэн, бүхий л баримт үнэнийг илтгэсэн агуулга үгүйлэгдэж байгаагаас олон нийтийн үл итгэлцэл, эрс шүүмжлэлийн бай болох нь олонтаа тохиолдож байна. Ийм жишээнд "Таван толгойн" хувьцаа тойрсон маргаан, мэтгэлцээн, Оюу толгой гэрээтэй холбоотой олон нийтийн үгүйсгэл шүүмжлэлийг тэмдэглэж болно.)

- **Нэгдмэл байх** (төрийн байгууллагын бүхий л нэгж, салбар нь нэгэн адил байр суурь, үзэл тайлбарыг баримталж байх ёстой. Манай өнөөгийн төрийн мэдээлэлд салбар хоорондын зөрчил, үгүйсгэл цөөнгүй тохиолддог нь олон нийтийн шүүмжлэл, үгүйсгэлийг хөөрөгддөг нь нууц биш. Үүнд хотын удирдлага ба яам хоорондын ажил үүргийн асуудлаар зөрчилт тайлбар, ХЗДХ-ийн яам Тагнуулын дээд сургууль тойрсон маргаан Ерөнхийлөгчийн төвшинд хүрсэн жишээ зэргийг нэрлэх байна.)

Мэдээж энэхүү үүрэг зарчмыг бодит хэрэг ажил болгоход мэргэшсэн, өндөр төвшиний ажилтнуудын нэгдмэл томоохон хүчин чармайлт, ухаан сэтгэл хэрэгтэй нь ойлгомжтой. Харин манайд мэдээлэл харилцааны асуудлыг улс төрийн албан тушаал, улс төрчдийн ажил хэрэг мэтээр ханддаг зүй тогтол бий болсон нь нууц бишээ. Энэ нь ч төрийн мэдээллийн орон зайн зүй

зохист төлөвшил, хөгжил шинэчлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна. Түүнчлэн мэдээллийн ажил нь нэг талаар ямар нэг шүүмжлэл үгүйсгэлийн хариу няцаалт, сөрөг мэдэгдэл нөгөө талаас албан тушаалтны ажил үүргийн тайлан, ухуулга сурталчилгаа болоод байгаа нь бодит үнэн. Ер нь хэвлэлийн төлөөлөгч, ажилтан нь дарга нарын "мууд барьдаг муна" болоод удаж байна гэхэд хилсдэхгүй. Нэн ялангуяа томоохон албан тушаалтан, эрх мэдэлтний хэвлэл мэдээллийн ажилтан нь улс төрийн зөрчил, өрсөлдөөний хамгийн эхний золиос болдог нийтлэг үзэгдэл амь бөхтэй оршсоор байна. Төр засгийн нэр хүнд, байр суурь олон нийтийн дунд унах, шүүмжлэл, мэтгэлцээний гол сэдэв болох нь эцсийн дүндээ албан тушаалтны ажил хариуцлагын "балаг" болохоос хэвлэл мэдээллийн хэрэгслийн, түүнтэй ажилладаг төлөөлөгчийн алдаа биш гэдэг нь энгийн ухамсрын төвшинд ч ойлгомжтой зүйл.

Үүнийг ч орчин үеийн өрнөдийн төрийн мэдээллийн үйл хэлбэрийг тоочих байдлаар харьцуулан дүгнэхэд тодорхой болно. Өөрөөр хэлбэл төрийн мэдээллийн албан хийх ёстой ажил үүрэг нь

а) зорилго болгож буй үзэл, агуулгыг онцлох;

б) тодорхой үйл явдал, баримтад олон нийтийн анхаарлыг чиглүүлэх;

в) үзэл дүгнэлт, хандлагыг зүй зохист чиглэлд хөтлөх;

г) төрийн бодлого, үйл хэрэгт олон нийтийн "дуу хоолой"-н дэмжлэг олох;

д) төрийн бодлого, байр суурийн нэгдмэл байдлыг хадгалах;

е) олон нийттэй шууд нээлттэй харилцах замаар эерэг таатай санаа бодлыг төлөвшүүлэх эдгээр ажээ.

Тэгэхлээр үүний өмнө өгүүлсэн манай өнөөгийн төрийн мэдээллийн хандлага цаг үе, нийгмийн хөгжил, эрэлтээс хоцрогдсон, зохист бус болох нь ойлгомжтой байна. Тэгээд ч төрийн мэдээлэл нь албаны эх сурвалж үйл явдал, асуудлыг олон нийтэд нээн

тодотгогч гэсэн давуу тал, онцлогоо хадгалан, хэвлэл мэдээллийнхэний үзэл байр суурьд нөлөөлөгч хүчин байж чадваас сая үүрэг нөлөөгөө сонгодог утгаар нь оршоох бөлгөө. Үүнд ч төрийн эрх мэдлээ нийгмийн зохист хөгжилд үйлчлүүлэх, засаглахуйн ихээхэн хувь хэмжээ нь ноогдох болно. Нээлтэй, ардчилсан төрийн байгууллага тогтолцоо нь ч мэдээллийн эрүүл саруул, дэг журамт, хэм хэмжээ бүхий орчинд бодит зүйл, эрхэмлэл болох нь тодорхой.

Ишлэл

¹ МХХ-ийн мониторингийн судалгааны 2010 оны дүнгээр тооцов.

² *Green P. S.* 1994. *Winning PR Tactics*. London, p. 37.

³ *Seitel F. P.* 1992. *The Practice of PR*. NY., p. 105.

⁴ *Блэк С.* 2000. Паблик рилейшнз. М., с. 45.

⁵ *Maltese J. A.* 2000. *Spin control*. White house office of communication of Presidential news. Chapel Hill, p. 56.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Green P. S.* 1994. *Winning PR Tactics*. London.

2. *Seitel F. P.* 1992. *The Practice of PR*. NY.

3. *Maltese J. A.* 2000. *Spin control*. White house office of communication of Presidential news. Chapel Hill.

4. *Блэк С.* 2000. Паблик рилейшнз. М.

5. *Болд-Эрдэнэ Б., Өнөрбаяр Г.* 2010. Төрийн байгууллагын мэдээлэл харилцаа. УБ.

6. *Зулькафилъ М.* 2010. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ

7. *Блажнов Е. А.* 1994. Паблик рилейшнз. М.

8. *Катлип С. М., Центер А. Х., Брум Г. М.* 2001. Паблик рилейшнз теория и практика. М.

9. *Почепцов Г. Г.* 2002. Паблик рилейшнз для профессионалов. Киев.

Резюме

В этой статье автор рассматривает проблемы развития и становления информационной коммуникации правительства Монголии. Описывая современное состояние информационной коммуникации, автор считает, что при соблюдении следующих пяти принципов существенно улучшится её эффективность: комплексность, организованность, открытость (гласность), системность и целостность.